





ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ХАМРАЛТ, ОРЛОГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)



/Н.АРИУНАА/

2024 оны 12 сарын 18 өдөр

ХАМРАЛТ, ОРЛОГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)



/М.ОТГОНЦЭЦЭГ/

2024 оны 12 сарын 16 өдөр

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ОРЛОГО ШИМТГЭЛИЙН ТАСГИЙН
2024 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төс өв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт(хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.							
Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах							
	Нийгмийн даатгалын багц хууль	-	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	2024 оноос эхлэн салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэнтэй холбоо тойгоор нийт 6752 ажил олгогчийн нягтлан бодогч, захирлуудад шинэ системд бүртгүүлэх мэдээллийг шинэчлэх, даатгуулагчийн мэдээлэл болон регистрийн дугаарыг үнэн зөв оруулах, даатгуулагчийн төрлийн кодыг зөв сонгож тайлагнахад анхаарч аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчдыг тайлан шалгах цонхыг ашиглан алдаа зөрчилгүй тайлан баталгаажуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөөг ажиллаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны А/44, А/43 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрлийн код”-ыг ажил олгогчдод танилцуулан тушаалыг хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/61 тушаалаар салбарын хэмжээнд 2024 оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан албан журмын болон сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, ажил олгогч даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг шуурхай үзүүлэх, нийгмийн	100%

						даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	
1.1.2.	Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх.	-	Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь	2023 онд нийт 8,844 хүнийг сайн дурын даатгалд хамруулав.	Сайн дурын даатгуулагч албан бус хөдөлмөр эрхлэгчдийг шинээр хамруулах тоог өмнөх оноос 1,750 хүнээр нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.	2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 9410 сайн дурын даатгуулагч хамрагдсан байна. Үүнээс сайн дурын даатгалд 8100 даатгуулагч, 0-3 хүртэлх насны хүүхэдтэй эх 780 даатгуулагч, сайн дурын даатгалын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг эх-135 даатгуулагч, малчин, туслах малчин 12 гэрээ байгуулан сайн дурын даатгалд хамруулсан ба тайлант хугацаанд нийгмийн даатгалын санд 12762.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 10209.6 сая төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 80 хувиар биелүүлсэн байна. 2024 оны 4 дүгээр улиралд сайн дураар даатгуулах гухай гэрээ байгуулсан боловч хуулийн хугацаандаа шимтгэлээ төлөөгүй 465 даатгуулагчид нийт 18,9 сая төгрөгийн алданги ногдуулж алдангийн нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн. Программд 2 бүртгэл үүссэн 53 даатгуулагч мэдээллийг залруулан ногдуулалт хийж ажилласан.	80%
1.1.3.	Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх.	-	Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь	2023 онд нийт 5,176 ажил олгогч, 127,010 хүнийг албан журмын даатгалд хамруулав.	Ажил олгогчийн тоог 569, даатгуулагчийн тоог 3,417 нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/61 тушаалаар салбарын хэмжээнд 2024 оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан албан журмын болон сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, ажил олгогч даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг шуурхай үзүүлэх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийгмийн даатгалд хамрагдаагүй 1956,0 сая төгрөгийн цалингийн сан бүхий 569 аж ахуйн нэгж байгууллагын албан хүсэлтийг хүлээн авч, нийгмийн даатгалын программд шинээр бүртгэж, мэдээллийг бүрэн оруулж, орлогын байцаагчид хуваарилан ажиллалаа. Албан журмын даатгалд 3417 даатгуулагчийг шинээр хамруулсан.	100%
Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах							
2.1.3.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх.	-	Батлагдсан 475,122,382.6 төгрөгийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар,	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган	Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, иргэнийг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн хугацаанд төлүүлэх, өр авлага барагдуулах ажлуудыг зохион байгуулан ажилласны үр дүнд 4 улирлын байдлаар нийгмийн даатгалын санд 663 202,5 сая төгрөгийн шимтгэлийн орлого	100%

			өссөнөөр жигд биелүүлэн ажиллана.	биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 523359.0 төгрөгөөр буюу 110.1 хувиар биелүүлсэн..	биелүүлж, нийгмийн даатгалын санд 663 202 473.40 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна	төвлөрүүлэхээс 663 202,5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн.	
2.1.5.	Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж оны эхний үлдэгдэлээс бууруулах, үр дүнг тооцож хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т хүргүүлэх.		Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй хувиар бууруулна.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлага оны эхнээс 9,1 хувиар буурсан /өссөн/ байна.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30 хувиас доошгүй буурсан байна.	Газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталсан шимтгэлийн авлага барагдуулах, орлогын төлөвлөгөө биелүүлэх чиглэлээр 2024 онд хийж гүйцэтгэх хэлтсийн ажлын төлөвлөгөөг батлуулан өр авлага барагдуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.Үүнд: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 тушаал баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 6-д заасан Шимтгэлийн өр барагдуулахаар орлого шимтгэлийн байцаагч тус бүр аж ахуйн нэгж байгууллагуудад авлага барагдуулах чиглэлээр өр авлага үүссэн хугацаа, авлагын насжилт их хэмжээний өртэй, ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, шат дараалсан арга хэмжээ авч ажиллаа. 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийгмийн даатгалын санд 663 202,4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 41083,2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагатай гарсан бөгөөд орлогод эзлэх авлагын хэмжээ 6,1 хувь байна. Албан шаардлага: Урсгал авлага үүсгэсэн, сар дамнуулан шимтгэлээ төлдөг төсөвт байгууллагын удирдлага нягтлан бодогчдод урсгал авлага үүсгэхгүй байхад анхааруулж албан шаардлага хүргүүлж ажиллаа. Уулзалт, гэрээ: Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 10-аас дээш сая төгрөгийн буюу их хэмжээний өртэй 10030,9 сая төгрөгийн өртэй 91 ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, хуваарь гарган тэмдэглэл хөтөлж баталгаажуулснаар 4726,0 сая төгрөгийн өр авлагыг барагдуулсан. Цаашид гэрээний хугацаанд шимтгэлээ төлж барагдуулах, гэрээ зөрчсөн тохиолдолд дараагийн шат дараалсан арга хэмжээ авч ажиллахыг мэдэгдсэн. Цаашид гэрээний хугацаанд шимтгэлээ төлж барагдуулах, гэрээ зөрчсөн тохиолдолд дараагийн шат дараалсан арга хэмжээ авч ажиллахыг мэдэгдсэн. Данс хаах: Шимтгэлийн авлага барагдуулах гэрээний дагуу төлөлт зөрчсөн ажил олгогчийн харилцах дансны гүйлгээг зогсоох талаар ажил олгогчийн захирал, нягтлан	90%

					бодогчдод танилцуулж арилжааны банкнуудад мэдэгдэл хүргүүлснээр 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар гэрээ байгуулсан боловч гэрээг чөлөөтэй чөлөөтэй 18093,1 сая төгрөгийн өртэй 1342 байгууллагын харилцах дансны гүйлгээг зогсоосон 248 байгууллагын 3567,7 сая төгрөгийн авлагыг барагдууллаа. Шүүхэд нэхэмжилсэн: Авлага барагдуулах ажлын хүрээнд 2023 оны 11 сард нийт 4210,0 сая төгрөгийн шимтгэлийн өртэй 60 ажил олгогч, 2024 оны тайлант хугацаанд 6624,3 сая төгрөгийн өртэй 91 ажил олгогч нийт 151 ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулахаар харьяа анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. 2023-2024 онд шүүхэд шилжүүлсэн ажил олгогчдоос 29 байгууллагатай эвлэрсэн үүнээс 8 ажил олгогчийн 687,2 сая төгрөгийг бүрэн барагдаж, 17 ажил олгогчийн 1054,4 сая төгрөгийн авлага хэсэгчлэн барагдсан нийт 1732,6 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан. 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар шүүхэд шилжүүлсэн хаяг байршил тодорхойгүй шалтгаанаар анхан шатны шүүхээс материал буцсан 54 ажил олгогчийн хаяг байршил эзэн холбогдогч тодорхойгүй гэх үндэслэлээр шүүхээс буцсан тул эрэн сурвалжлах захирамж гаргуулахаар харьяа дүүргийн шүүхэд хүсэлт гаргасан. Үүнээс 27 ажил олгогчийг эрэн сурвалжлах шийдвэр гарсан тул анхан шатны материалыг бүрдүүлэн иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлэн ажиллаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн боловч авлага барагдахгүй удаашралтай байгаа байгууллагын авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Газрын дарга Н.Ариунаа, Орлого шимтгэлийн тасгийн дарга М.Отгонцэцэг, хууль эрхзүй хүний нөөцийн мэргэжилтэн В.Эрдэнэбат, өр авлага хариуцсан байцаагч Б.Энхмишээл нар Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга хурандаа Х.Оюунболд болон хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нартай ажил эрчимжүүлэх, хамтран ажиллах уулзалтыг 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгууллаа. Уулзалтаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн тус газраас нэхэмжлэлтэй 2390,1 сая төгрөгийн өртэй 17 ажил олгогчийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хийгдэж байгаа ажиллагаатай танилцаж, цаашид авсан арга хэмжээг 7 хоног бүр тэмдэглэл хөтлөн үлдэгдэл тулгаж, мэдээллээ солилцож ажиллахыг үүрэг болгосон. Мөн 1324,0 сая төгрөгийн өртэй 9 ажил олгогчийн гүйцэтгэх ажиллагааг ШШГТХ-н 27.2.6-т зааснаар төлбөр төлөгч иргэн, эсхүл төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үүсгэн
--	--	--	--	--	--

					байгуулагч, төлөөлөгч, тэдгээрийн эд хөрөнгийг эрэн сурвалжилж, олж тогтоох хүртэл хугацаагаар түдгэлзүүлсэн тул дээрх авлагыг хэрэгж барагдуулах, тухайн төлбөр төлөгчид эд хөрөнгө байгаа эсэхийг дахин шалгаж, гүйцэтгэх ажиллагааг танилцуулж ажиллах талаар санал солилцлоо. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар шилжүүлсэн нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 35 аж ахуйн нэгж байгууллагын 4719,2 сая төгрөгийн өр барагдуулах явцыг эрчимжүүлэх зорилгоор өр барагдуулалтын судалгаа гаргаж, шийдвэр гүйцэтгэгч болон байцаагч нарт бодит мэдээллээр хангаж ажиллаж байна. Үүнээс 679,7 сая төгрөгийн өртэй 9 аж ахуйн нэгж байгууллагын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр төлөгч-иргэн, эсхүл төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, төлөөлөгч, тэдгээрийн эд хөрөнгийг эрэн сурвалжилж, олж тогтоох хүртэл шалтгаанаар түдгэлзүүлсэн байна. Шимтгэл төлөх дансны дугаарыг брошюр болгон бэлтгэн шийдвэр гүйцэтгэх газрын мэдээллийн самбарт байршууллаа. 2024 оны 04 дүгээр улирлын байдлаар 3393,7 сая төгрөгийн өртэй 25 аж ахуйн нэгж байгууллагад өр барагдуулах гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа бөгөөд 150,5 сая төгрөгийн өртэй ажил олгогчийн авлага бүрэн барагдаж ажил олгогчийн 237,0 сая төгрөгийг авлага хэсэгчлэн барагдуулсан. Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй хуримтлагдсан авлагын 21,1 тэрбум төгрөг буюу 48% хувийг худалдаа үйлчилгээ, барилга, зам тээвэр, уул уурхайн салбарууд эзэлж байна. Зам, барилгын салбар нь улсаас тендер авч урьдчилсан гүйцэтгэлийн санхүүжилтийг тухайн ажил олгогч хариуцаж гүйцэтгэдэг ба барилга болон замын гүйцэтгэл бүрэн дууссаны дараа улсын төсвөөс санхүүжилтээ авдаг. Төслийн хугацаанд бараа материал, тээврийн үнэ огцом нэмэгдэж дээрх салбарууд алдагдал хүлээж, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаандаа төлж чадахгүй өр хуримтлагдаж байна. Газрын үйл ажиллагаанаас үл хамаарч нийгэм, эдийн засгийн хямрал нөлөөлж иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд шимтгэлээ төлөхгүй удаашралтай байна.	
2.1.6.	Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг барагдуулах	Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй гарсан байна.	Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог хийсэн.	Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог тухай бүр хийж, өглөггүй байна.	2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 9410 сайн дурын даатгуулагч хамрагдсан байна. Үүнээс сайн дурын даатгалд 8100 даатгуулагч, 0-3 хүртэлх насны хүүхэдтэй эх 780 даатгуулагч, сайн дурын даатгалын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг эх-135 даатгуулагч, малчин, туслах малчин 12 гэрээ байгуулан сайн дурын даатгалд хамруулсан ба тайлант хугацаанд нийгмийн даатгалын санд 12762.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 10209.6 сая төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 80 хувиар биелүүлсэн байна.	85%

Дөрөв. Төрийн үйлчилгээний газар хүртээмжийг сайжруулах зорилт.

Төрийн захиргааны удирдлагыг манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, тууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах

4.1.2.	ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах.	-	Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 89,1 %-тай хэрэгжсэн байна.	Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	2024 оны 4 дүгээр улирлын байдлаар ирсэн бичиг, өргөдөл, гомдлыг цаасан суурьтайгаар болон Абле, Edos программаар цахимаар хүлээн авч холбогдох байцаагчид шилжүүлэн хуулийн хугацаанд шийдвэрлүүлж ажиллаж байна. Газрын даргын хурлаар өгсөн чиглэл, үүрэг даалгаврыг танилцуулж албан хаагчдын албан хэрэг хөтлөлт, явцын тэмдэглэл хөтлөх ажил олгогчоос ирүүлсэн албан хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд ажил олгогчоос ирүүлсэн 285 албан хүсэлт, анхан шатны нотлох баримтыг үндэслэн даатгуулагчийн цалин, төрлийн кодыг залруулсан байна. Мөн даатгуулагчийн өргөдөл, нотлох баримтыг үндэслэн 152 даатгуулагчийн үндсэн мэдээлэл, овог нэр, регистрийг өөрчилж бүртгэл засав. Тайлант хугацаанд албан бичиг шийдвэрлэлтийн биелэлт 100% байна.	100%
Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах							
4.2.2.	Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах;	-	Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 52 удаагийн сургалтад 19653 иргэд, даатгуулагчийг хамруулсан.	Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна.	2024 оноос эхлэн салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотойгоор 2024 оны 02 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд 50 ажил олгогчийн нягтлан бодогчдыг хамруулан танхимаар сургалт зохион байгуулж ажил олгогчийг шинэ системд бүртгүүлэх мэдээллийг шинэчлэх, даатгуулагчийн мэдээлэл болон регистрийн дугаарыг үнэн зөв оруулах, даатгуулагчийн төрлийн кодыг зөв сонгох, тайлангаа хуулийн хугацаанд цахимаар ирүүлэхийг анхааруулж зөвлөгөө өгч ажилласан. Ажил олгогчдын зөвлөгөөн зохион байгуулах: Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд, журам заавар, цахим үйлчилгээний талаар аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчдод сурталчлан таниулах, шимтгэл төлөлтийн тайланг үнэн зөв хугацаанд нь гаргах талаар мэдээлэл өгөх зорилгоор Ажил олгогч захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудын сургалт, зөвлөгөөнийг 2024 оны 11 сарын 20-ны өдөр танхимаар зохион байгууллаа.	100%

					Зөвлөгөөнд урилгаар “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт, цаашид анхаарах асуудлууд сэдвээр НД-ын БХСГ-ын НД-ын бодлого хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн улсын байцаагч М.Бямбадулам оролцлоо. ХНХСайдын 2023 оны А/199 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан илгээх, хүлээн авах, хянах, баталгаажуулах журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цахимаар тайлан илгээх талаар зөвлөгөө мэдээлэл өгч, танилцуулсан. Тус газар нь уг сургалт, зөвлөгөөний үеэр Нийгмийн даатгалын хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, даатгуулагчийнхаа нийгмийн баталгааг хангаж, улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулж байгаа 5 байгууллагыг “Шилдэг ажил олгогч”-оор шалгаруулж, өргөмжлөлөөр шагнаж урамшуулсан. Иргэд даатгуулагч, ажил олгогчийн захирал нягтлан бодогчдод нийгмийн даатгалын ажил үйлчилгээг хүртээмжтэй шуурхай хүргэх, нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг танилцуулах, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх сургалтыг тогтмол зохион байгуулж, шинээр ажил олгогчоор бүртгүүлэх заавар, гарын авлага QR код, сайн дурын даатгалд хамрагдах иргэдэд зориулсан мэдээлэл, гарын авлага QR кодыг бэлтгэн: 1. Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын нэг цэгийн үйлчигээний танхимд 2. Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн газрын нэг цэгийн үйлчилгээний танхим хуулийн этгээдийн бүртгэл хэсэгт, мэдээллийн самбарт 3. Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн мэдээллийн самбарт 4. Чингэлтэй Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтсийн нэг цэгийн үйлчилгээний танхим, мэдээллийн самбарт тус тус байршууллаа. Хувиар хөдөлмөр эрхлэгч иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сайн дурын даатгал, тэтгэвэр тэтгэмжийн даатгал, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ, бусад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, хамрагдалтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, ач холбогдлын талаар мэдээлэх, таниулах зорилгоор Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг зах худалдааны төвүүдтэй хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлэн “Нээлттэй хаалганы өдөрлөг” явуулын үйлчилгээг иргэд даатгуулагчдад хүргэн ажиллаж байна.
--	--	--	--	--	---

					Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар: Чингэлтэй Дүүргийн засаг даргын тамгын газартай хамтран дүүргийн нийт иргэд даатгуулагчдад сайн дурын даатгал, тэтгэврийн даатгалын талаар зөвлөгөө мэдээллийг хүргэх, сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд видео танилцуулгыг бэлтгэн 1-24 дүгээр хороодын иргэний танхимаар дамжуулан хүргэж байна. Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомжийг сурталчлан таниулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх “Зөвлөө, Тусалъя” явуулын үйлчилгээг 2024 оны 06 дугаар сарын 5,6-ны өдрүүдэд Бөмбөгөр худалдааны төв, Хүчит шонхор худалдаан төв, Нарантуул- 2 төвүүдийн түрээслэгч нарт сайн дурын даатгал, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмж, тэтгэврийн даатгалын талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа. Нээлттэй хаалганы өдөрлөгт тэтгэврийн даатгал-173, сайн дурын даатгалын талаар 81, тэтгэмжийн даатгалын талаар 10, ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайлантай холбоотой 23 нийт 278 иргэд, даатгуулагчдад зөвлөгөө өгч ажилласан. 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Нийгмийн даатгалын ажил үйлчилгээг иргэдэд сурталчлах, хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн ач холбогдлын талаар ойлголт өгөх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг дараах чиглэлийн хүрээнд 10:00-16:00 цагийн хооронд нийт 309 иргэнд хүрч, арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид, МСҮТ, их дээд сургуулийн оюутнуудыг хамруулсан, нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах зорилготой "Даатгалтай ирээдүй" сэдэвт сургалтыг 3 дугаар сарын 26-29-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус аяны хүрээнд ерөнхий боловсролын 5 болон 50 дугаар сургуулийн 42 сурагч, 2 их дээд сургуулийн нийт 41 оюутан сурагч хамрагдлаа. Сургалтын явцад 9 оюутан, сурагчид гар утасны аппликэйшн суулгаж, нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар товч мэдээлэл хүргэсэн.	
Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх						
Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн	-	Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх	Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан.	Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн	Тус газраас иргэд даатгуулагч, ажил олгогчийн захирал нягтлан бодогчдод нийгмийн даатгалын ажил үйлчилгээг 95%	

4.4.1.	гүйцэд байх	бүрдүүлсэн			бүрдүүлсэн байна. - Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна.	хүртээмжтэй шуурхай хүргэх, нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг танилцуулах, мэргэжилтэйд газрын зөвлөгөө өгөх сургалтыг тогтмол зохион байгуулж, шинээр ажил олгогчоор бүртгүүлэх заавар, гарын авлага QR код, сайн дурын даатгалд хамрагдах иргэдэд зориулсан мэдээлэл, гарын авлага QR кодыг бэлтгэн гаргасан. QR уншуулан даатгуулагчийн ажил мэргэжлийн ангилал, даатгуулагчийн төрлийн кодыг харах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Тайлан хугацаанд SICOS системээр шимтгэлийн төлөлтийн тайланг хянаж баталгаажуулсан бөгөөд тайлан авалтын хувь 95% байна.	
4.4.2.			Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх	Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан.	Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна.	2024 оны тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан тооцоо хийсэн 6816 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн өдрийн А/199 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журмын дагуу хүлээн авч, хянан цахимаар баталгаажуулан, даатгуулагчийн төрлийг давхардуулан бүртгэхгүй байх талаар нягтлан бодогч нарт заавар зөвлөгөө өгч ажилласан.	
	Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх		Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байх МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн		Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна. МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл,	Сайн дурын даатгуулагчийн мэдээлэл аймаг, дүүрэгтэй давхардсан даатгуулагч эх-53, сайн дурын даатгуулагчтай давхардсан-28 даатгуулагч эхийн бүртгэлийг залруулсан. Давхар ногдуулалт хийсэн 45 даатгуулагч, Ажил олгогчийн цалин, сайн дурын даатгуулагч эх гэрээтэй давхардсан 74 даатгуулагчийн мэдээллийг засварлаж ногдуулсан. Сайн дурын даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 95 өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. НДЕГ-ын МТТ-өөс 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 09 тоот албан бичгээр даатгуулагчийн цалингийн мэдээллийг хөрвүүлэх тухай чиглэлийг ирүүлсэн бөгөөд тайлант хугацаанд өргөдлийн дагуу 55 даатгуулагчийн мэдээллийг засах, регистрийн дугаарыг нэгтгэж мэдээллийг баазыг шинэчлэсэн.	95%

		хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх		албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна.	Сикос системд өргөдөл, албан хүсэлтээр ирүүлсэн 266 даатгуулагчийн буруу регистрийн дугаартай цалинг зөв регистрийн дугаарт хөрвүүлж нэгтгэсэн.	
--	--	---	--	--	---	--

---oOo---



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ХАМРАЛТ, ОРЛОГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ 4 УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН
Орлого шимтгэлийн талаар

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, иргэнийг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн хугацаанд төлүүлэх, авлага барагдуулах шат дараалсан ажлуудыг зохион байгуулан ажиллалаж 4 улирлын байдлаар нийгмийн даатгалын санд **663202,5** сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэхээс **663202,5** сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг **100** хувиар биелүүлсэн.

Д/Д	Огноо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Эзлэх хувь
1	2024 оны 01-р сар	40 105 287,00	49 573 438,54	123%
2	2024 оны 02-р сар	43 116 972,40	47 646 609,00	111%
3	2024 оны 03-р сар	57 720 803,00	62 105 594,50	108%
4	2024 оны 04-р сар	47 477 917,70	62 884 985,19	132%
5	2024 оны 05-р сар	53 414 787,30	60 339 334,51	113%
6	2024 оны 06-р сар	61 786 892,20	59 948 369,93	97%
7	2024 оны 07-р сар	43 944 080,90	59 882 897,40	136%
8	2024 оны 08-р сар	52 474 662,90	58 864 184,17	113%
9	2024 оны 09-р сар	56 508 552,00	57 190 069,16	101%
10	2024 оны 10-р сар	53 560 004,70	65 062 292,11	121%
11	2024 оны 11-р сар	56 508 553,10	56 508 553,10	100%
12	2024 оны 12-р сар	96 583 960,20	96 583 960,20	100%
	Нийт дүн	663 202 473,30	663 202 473,30	100%

2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийгмийн даатгалын санд **663 202,4** сая төгрөгийн орлого төвлөрүүлж, **41083,2** сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагатай гарсан бөгөөд орлогод эзлэх авлагын хэмжээ **6,1** хувь байна.

Хамралт:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/61 тушаалаар салбарын хэмжээнд 2024 оныг "Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх" жил болгон зарласантай холбогдуулан албан журмын болон сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, ажил олгогч даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг шуурхай үзүүлэх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийгмийн даатгалд хамрагдаагүй **1956,0** сая төгрөгийн цалингийн сан бүхий 569 аж ахуйн нэгж байгууллагын албан хүсэлтийг хүлээн авч, нийгмийн даатгалын программд шинээр бүртгэж, мэдээллийг бүрэн оруулж, орлогын байцаагчид хуваарилан ажиллалаа. Албан журмын даатгалд **3417** даатгуулагчийг шинээр хамруулсан.

Тус газраас иргэд даатгуулагч, ажил олгогчийн захирал нягтлан бодогчдод нийгмийн даатгалын ажил үйлчилгээг хүртээмжтэй шуурхай хүргэх, нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг танилцуулах, мэргэжил аргагүйн зөвлөгөө өгөх сургалтыг тогтмол зохион байгуулж, шинээр ажил олгогчоор бүртгүүлэх заавар, гарын авлага QR код, сайн дурын даатгалд хамрагдах иргэдэд зориулсан мэдээлэл, гарын авлага QR кодыг бэлтгэн:

1. Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын нэг цэгийн үйлчилгээний танхимд
2. Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн газрын нэг цэгийн үйлчилгээний танхим хуулийн этгээдийн бүртгэл хэсэгт, мэдээллийн самбарт
3. Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн мэдээллийн самбарт
4. Чингэлтэй Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтсийн нэг цэгийн үйлчилгээний танхим, мэдээллийн самбарт тус тус байршууллаа.



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗАР

ШИНЭЭР АЖИЛ ОЛГОГЧООР
БҮРТГҮҮЛЭХ



АЛБАН ХҮСЭЛТЭЭ
CHINGELTEI@NDAATGAL.MN
ЦАХИМ ХАЯГААР ИЛГЭЭХ БОЛОМЖТОЙ

1. АЛБАН ХҮСЭЛТ /ЗАГВАР/
2. ДАНСНЫ ДУГААР
3. ДААТГУУЛАГЧИЙН ТӨРЛИЙН КОД
4. АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ /ҮО-ХУВЬ/

7000-7790
7000-7798

chingeltei@ndaatgal.mn

chingeltei.ndaatgal.mn



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗАР

Сайн дурын даатгалын үйлчилгээ



1. Сайн дурын даатгуулагч гэж юу юм?
2. Сайн дурын даатгалын гэрээг хэрхэн байгуулах вэ?
3. Сайн дурын даатгалд даатгуулахдаа шимтгэл төлөх орлогоо хэрхэн тодорхойлох вэ?
4. Сайн дурын даатгуулагч нийгмийн даатгалын санд сар бүр хэдэн төгрөгний хэмжээг төлөх вэ?
5. Сайн дурын даатгал төлсөн дараахыг мэдэвчлэл

7000-7790
7000-7798


chingeltei@ndaatgal.mn

chingeltei.ndaatgal.mn



Тайлан авах ажлын хүрээнд:

2024 оноос эхлэн салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлж эхлэсэнтэй холботойгоор ажил олгогчийг шинэ системд бүртгүүлэх мэдээллийг шинэчлэх, даатгуулагчийн мэдээлэл болон регистрийн дугаарыг үнэн зөв оруулах, даатгуулагчийн төрлийн кодыг зөв сонгож тайлагнахад анхаарч аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчдыг тайлан шалгах цонхыг ашиглан алдаа зөрчилгүй тайлан баталгаажуулах болон холбогдох мэдээ мэдээлэл мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч тайлант хугацаанд ажил олгогчийн нягтлан бодогчдод сургалт зохион байгууллаа.



2024 оны 4 дүгээр улиралд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан тооцоо хийсэн **5234** ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн өдрийн А/190 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтын дагуу хүлээн авч, хянан баталгаажуулан, байгууллага тус бүрээр хавтас нээж зохих журмын дагуу ажиллаж байна.

Вэб программаар илгээсэн зөв тайлан хүлээн авах, даатгуулагчийн мэдээлэл болон регистрийн дугаарыг үнэн зөв оруулах, даатгуулагчийн кодыг зөв сонгож тайлагнахад анхаарч аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчдыг тайлан шалгах цонхыг ашиглан алдаа зөрчилгүй тайлан баталгаажуулах болон холбогдох мэдээ мэдээлэл мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаж байна.

2024 оны 4 дүгээр улиралд ажил олгогчоос цалин залруулга, нөхөн тайлан, ажил олгогчийн үйл ажиллагаатай холбоотойгоор нийт **285** албан хүсэлт, даатгуулагч иргэдээс регистр нэгтгэх, даатгуулагчийн үндсэн мэдээлэл засуулахаар нийт **152** хүлээн авч, холбогдох анхан шатны баримтыг үндэслэн хүлээн авч системийн шинэчлэл дууссаны дараа шийдвэрлэхээр хүлээгдэж байна.

Архивын ажлын хүрээнд:

Газрын даргын баталсан 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 тоот удирдамжийн дагуу Орлого, шимтгэлийн тасгийн байцаагч нарын хариуцан ажилладаг ААНБ-ын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан болон ногдуулалт, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, даатгуулагчийн төрөл, тайлан авалтын хугацаа, нөхөн тайлангийн үндэслэл болон залруулгын тайлан зэргийг мэдээллийн сантай тулган шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрэн арилгуулан 2023 оны 01 сараас 12 сарын ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хяналт шалгалтын байцаагчаар шалгуулан, хадгаламжийн нэгж үүсгэн архивд шилжүүлсэн.



Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага бууруулах талаар

Газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталсан шимтгэлийн авлага барагдуулах, орлогын төлөвлөгөө биелүүлэх чиглэлээр 2024 онд хийж гүйцэтгэх хэлтсийн ажлын төлөвлөгөөг батлуулан өр авлага барагдуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 тушаал баталсан "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ын 6-д заасан Шимтгэлийн өр барагдуулахаар орлого шимтгэлийн байцаагч тус бүр аж ахуйн нэгж байгууллагуудад авлага барагдуулах чиглэлээр өр авлага үүссэн хугацаа, авлагын насжилт их хэмжээний өртэй, ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, шат дараалсан арга хэмжээ авч ажиллаа. 2024 оны эхний авлага **38483,2** сая төгрөгийн авлагаас 2024 оны 04 дүгээр улирлын байдлаар **41083,2** сая төгрөг болж 6,7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Албан шаардлага: Урсгал авлага үүсгэсэн, сар дамнуулан шимтгэлээ төлдөг төсөвт байгууллагын удирдлага нягтлан бодогчдод урсгал авлага үүсгэхгүй байхад анхааруулж албан шаардлага хүргүүлж ажиллаа.

Уулзалт, гэрээ: Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 10-аас дээш сая төгрөгийн буюу их хэмжээний өртэй **10030,9** сая төгрөгийн өртэй **91** ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, хуваарь гарган тэмдэглэл хөтөлж баталгаажуулснаар **4726,0** сая төгрөгийн өр авлагыг барагдуулсан. Цаашид гэрээний хугацаанд шимтгэлээ төлж барагдуулах, гэрээ зөрчсөн тохиолдолд дараагийн шат дараалсан арга хэмжээ авч ажиллахыг мэдэгдсэн.

Данс хаах: Шимтгэлийн авлага барагдуулах гэрээний дагуу төлөлт зөрчсөн ажил олгогчийн харилцах дансны гүйлгээг зогсоох талаар ажил олгогчийн захирал, нягтлан бодогчдод танилцуулж арилжааны банкнуудад мэдэгдэл хүргүүлснээр 2024 оны 4 дүгээр улиралд 18093,1 сая төгрөгийн өртэй **1342** байгууллагын харилцах дансны гүйлгээг зогсоож **248** байгууллагын **3567,7** сая төгрөгийн авлагыг барагдууллаа.

Шүүхэд нэхэмжилсэн: Авлага барагдуулах ажлын хүрээнд 2023 оны 11 сард нийт 4210,0 сая төгрөгийн шимтгэлийн өртэй 60 ажил олгогч, 2024 оны тайлант хугацаанд **6624,3** сая төгрөгийн өртэй 91 ажил олгогч нийт **151** ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулахаар харьяа анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. Үүнээс 29 ажил олгогчийн шийдвэр эцэслэн гарсан ба 54 ажил олгогчийн хаяг байршил эзэн холбогдогч тодорхойгүй гэх үндэслэлээр шүүхээс буцсан тул эрэн сурвалжлах захирамж гаргуулахаар харьяа дүүргийн шүүхэд хүсэлт гаргасан. Үүнээс 27 ажил олгогчийг эрэн сурвалжлах шийдвэр гарсан тул анхан шатны материалыг бүрдүүлэн иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлэн ажиллаж байна.

Эрэн сурвалжлах ажиллагаа хийгдэж буй аж ахуйн нэгж байгууллагыг жагсаалтаар харуулбал:



№	Ажил олгогчийн нэрс	Регистер	Төлөх шимтгэлийн дүн /төгрөгөөр/	Алданги /төгрөгөөр/	Нийт нэхэмжилсэн /төгрөгөөр/	Шүүхийн шийдвэрийн дугаар
1	КААБА КОНКРЕТ ХХК	6441971	83 866 277	41 933 138	125 799 415	182/Ш32023/16119
2	ЭМ ТИ ЭС ЭЛИТ КЛАСС ХХК	6710719	7 925 740	3 962 870	11 888 610	182/Ш32023/15532
3	ЭН ПИ ЭМ ХХК	5193028	18 571 650	9 285 825	27 857 475	182/Ш32023/16781
4	СИМПЛЕКССОЛЬЮШНС КОНСТРАКШН ХХК	5747473	2 355 240	1 177 620	3 532 860	182/Ш32023/16158
5	ФЛОВЕРФУРНАСЕ ХХК	5574854	10 443 769	5 221 885	15 665 654	183/Ш32023/22497
6	ЭС СИ ЖИ ХХК	5420717	6 947 330	3 473 665	10 420 995	102/Ш32023/20658
7	РОМА ИНВЕСТМЕНТ ХХК	5597781	56 000 000	27 896 650	83 896 650	183/Ш32023/23582
8	ТАЙШИРЫН ХҮДЭР ХХК	5243904	47 337 861	23 668 931	71 006 792	183/Ш32024/01365
9	ГОЛЛАНД СОНГИНО ХХК	6171281	3 614 409	1 807 205	5 421 614	181/Ш32024/01422
10	ГРӨВТ АССЕТ МЕНЕЖМЕНТ ХХК	6792634	37 859 888	18 870 544	56 730 432	182/Ш32023/16095
11	КИНГ КОМФОРТ СЕРВИС ХХК	6449387	46 120 747	23 060 374	69 181 121	182/Ш32023/16540
12	МОНГОЛ ХҮСЛЭН ХХК	2866897	2 058 288	1 029 144	3 087 432	183Ш32023/22229
13	ЭДИМҮҮН ХХК	5240611	39 318 838		39 318 838	182/Ш32021/08904
14	ЖИНСОЛОН ХХК	5147549	2 140 378	1 070 189	3 210 567	181/Ш32023/19791
15	ЦЭЦ-УРАН ХХК	4256492	13 975 676	6 987 838	20 963 514	102/Ш32023/20051
16	МОН ЛЕД ЮНАЙТЕД ХХК	6134343	102 917 711	45 773 756	148 691 467	182/Ш32024/03760
17	КҮЭН БҮЛ ХХК	6214126	47 965 841	23 922 080	71 887 921	182/Ш32024/02879
18	БЭЙС ӨРГӨӨ ХХК	5371899	6 690 218	3 345 109	10 035 327	182/Ш32024/02778
19	АМИН ИНВЕСТ ХХК	6188346	23 735 844	12 026 338	35,762,182	182/ШШ2024/03089
20	АШИД ОРГИЛУУН ХХК	5289637	9 757 140	4 878 570	14,635,710	182/ШШ2024/03146
21	ЭЙЧ АР ДАЙМОНД ХХК	6120997	17 282 636	8 641 318	25,923,954	182/ШШ2024/03126
22	МИКРОБ БИОМ ХХК	6034608	10 938 400	5 121 382	16,059,782	182/Ш32024/09973
23	МНС АГРО ХХК	4274458	104260225	45570330	149,830,555	182/ШШ2024/03216




24	ХӨХ АЗИЙН ХУРДНЫ ЗАМ ХХК	6701191	16 175 200	8 087 600	24,262,800	182/Ш32024/04948
25	ГЕОМИН	2866773	103 221 064	27702059	130,923,123	182/ШШ2024/03125
26	ЛЭЛМИНЕРАЛ ХХК	5900972	258 184 651.66	126 854 214	385,038,866	182/ШШ2024/03217
27	СИ ЭЙ И МИНЕРАЛС ХХК	5923441	214 276 548	91 408 431	305,684,979	182/Ш32024/04554
28	МОНГОЛ ТАЖИМАЯА ХХК	6424406	32 998 920	16 499 460	49,498,380	182/ШШ2024/03230
29	БАМБАР ИНЖ ХХК	2062852	5 536 001	2 768 000	8,304,001	182/ШШ2024/03127
30	ТЭРГҮҮН СҮРЭГ ХХК	5777496	14 233 149	7 116 575	21,349,724	182/ШШ2024/03214
31	ОАСИСГРИЙН ХХК	5242533	45 531 229	22 682 058	68,213,287	182/ШШ2024/03125
32	СЕРЖ ЭНД ФҮҮДС ХХК	5797535	27 500 000	13 750 000	41,250,000	182/Ш32024/10267
33	ГАБСУ ТРЕЙД ХХК	6599028	148 357 584	55 933 527	204,291,111	183/Ш32024/11154
34	ХАЙРЫН ХОТ ХХК	5210178	110 845 920	53 078 360	163,924,280	182/ШШ2024/03229
35	ХЕФЕСТ ХХК	5059062	41 905 295	20 763 758	62,669,053	182/Ш32024/10778
36	БУНО БРИДЖ ХХК	6563015	14 320 000	7 138 800	21 458 800	182/Ш32024/12696
37	ВМС ХХК	5128374	10 584 000	5 260 752	15 844 752	182/Ш32024/12636
38	ДАРХАН ШИЙР ХХК	2649896	3 924 684	1 962 342	5 887 026	182/Ш32024/119654
39	ЛАЙТТАУЭР ДРИЛЛИНГ ХХК	5530644	10 465 140	5 232 570	15 697 710	183/Ш32024/06249
40	МОНГОЛ АЛТАЙН ЦАГ ХХК	6236685	27 098 748	13 549 374	40 648 122	182/Ш32024/12071
41	ЮНИ АССОШЭЙТ ХХК	5402522	41 348 336	20 674 168	62 022 504	182/Ш32024/13013
42	ПИЙС АЛЮМИНУМ ХХК	5371325	61 297 400	28 731 948	90 029 348	182/ШШ32024/1133 1
43	БАЙЛЖУУР ХХК	6059058	11 381 700	5 690 850	17 072 550	182/Ш32024/12837
44	ВРМ ХХК	4395166	7 592 600	3 796 300	11 388 900	102/Ш32024/12356
45	АЖ КОНСТРАКШН ХХК	2569922	37 884 924	18 733 618	56 618 542	182/Ш32024/12064



46	ИХ ТҮҮХТ ЗАМ ХХК	5707072	4 477 000	2 238 500	6 715 500	182/Ш32024/12698
47	АВСТРАЛИАН ЮТИЛИТИЕС ХХК	6092683	7 746 289	3 873 144	11 619 433	104/Ш32024/02132
48	ПИЙС АЛЮМИНУМ ХХК	5371325	61 297 400	28 731 948	90 029 348	182/ШШ32024/1133 1
49	ЖУНАГДЭЛГЭРЭХ ХХК	5369436	27 657 000	13 828 500	41 485 500	182/Ш32024/12637
50	БИ ЭЙ ЭН БИ ХХК	5466695	5 404 602	2 702 302	8 106 904	101/Ш32024/15932
51	ОПЕНМОНГОЛИА ЛИМИТЕД ХХК	5212715	1 824 000	912 000	2 736 000	182/Ш32024/13091
52	ИРМҮҮНТЕХ ХХК	5526337	5 050 825	2 525 412	7 576 237	182/Ш32024/11176
53	ИТ КОНСАЛТИНГ ХХК	5738032	9 300 835	4 650 417	13 951 252	182/Ш32024/12697
54	ГЭГЭЭН УВИДАС ХХК	5849195	25 854 219	12 919 717	38 773 936	182/Ш32024/12634
Нийт дүн			1 720 849 668.63	765 368 803	2 486 218 471.63	

Шүүхэд шилжүүлсэн 8 ажил олгогчийн **687,2** сая төгрөгийг бүрэн барагдаж, 17 ажил олгогчийн **1054,4** сая төгрөгийн авлага хэсэгчлэн барагдсан нийт **1732,6** сая төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн боловч авлага барагдахгүй удаашралтай байгаа байгууллагын авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Газрын дарга Н.Ариунаа, Орлого шимтгэлийн тасгийн дарга М.Отгонцэцэг, хууль эрхзүй хүний нөөцийн мэргэжилтэн В.Эрдэнэбат, өр авлага хариуцсан байцаагч Б.Энхмишээл нар Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга хурандаа Х.Оюунболд болон хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нартай ажил эрчимжүүлэх, хамтран ажиллах уулзалтыг 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгууллаа. Уулзалтаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн тус газраас нэхэмжлэлтэй 2390,1 сая төгрөгийн өртэй 17 ажил олгогчийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хийгдэж байгаа ажиллагаатай танилцаж, цаашид авсан арга хэмжээг 7 хоног бүр тэмдэглэл хөтлөн үлдэгдэл тулгаж, мэдээллээ солилцож ажиллахыг үүрэг болгосон. Мөн 1324,0 сая төгрөгийн өртэй 9 ажил олгогчийн гүйцэтгэх ажиллагааг ШШГтх-н 27.2.6-т зааснаар төлбөр төлөгч иргэн, эсхүл төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, төлөөлөгч, тэдгээрийн эд хөрөнгийг эрэн сурвалжилж, олж тогтоох хүртэл хугацаагаар түдгэлзүүлсэн тул дээрх авлагыг хэрхэн барагдуулах, тухайн төлбөр төлөгчид эд хөрөнгө



байгаа эсэхийг дахин шалгаж, гүйцэтгэх ажиллагааг танилцуулж ажиллах талаар санал солилцлоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар шилжүүлсэн нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 35 аж ахуйн нэгж байгууллагын **4719,2 сая** төгрөгийн өр барагдуулах явцыг эрчимжүүлэх зорилгоор өр барагдуулалтын судалгаа гаргаж, шийдвэр гүйцэтгэгч болон байцаагч нарт бодит мэдээллээр хангаж ажиллаж байна. Үүнээс **679,7 сая** төгрөгийн өртэй **9 аж ахуйн нэгж байгууллагын** шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр төлөгч-иргэн, эсхүл төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, төлөөлөгч, тэдгээрийн эд хөрөнгийг эрэн сурвалжилж, олж тогтоох хүртэл шалтгаанаар түдгэлзүүлсэн байна. Шимтгэл төлөх дансны дугаарыг брошюр болгон бэлтгэн шийдвэр гүйцэтгэх газрын мэдээллийн самбарт байршууллаа.

2024 оны 04 дүгээр улирлын байдлаар **3393,7 сая** төгрөгийн өртэй 25 аж ахуйн нэгж байгууллагад өр барагдуулах гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа бөгөөд 150,5 сая төгрөгийн өртэй ажил олгогчийн авлага бүрэн барагдаж 7 ажил олгогчийн 237,0 сая төгрөгийг авлага хэсэгчлэн барагдуулсан.

2024 оны 04 дүгээр улиралд шүүхээр нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй болох нь тогтоогдсон шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжийг албадан гүйцэтгүүлэхээр **1335,3 сая** төгрөгийн өр авлагатай **11 аж ахуйн нэгж байгууллагыг** Банк хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албанд шилжүүлсэн.

№	Ажил олгогчийн нэр	АО регистрийн дугаар	Шүүхийн мөнгөн дүн	Шүүхийн шийдвэрийн дугаар	Тайлбар
1	МЕД КОДЕРС ХХК	6837158	25 028 204	182/ШШ2024/00274 182/Ш32024/08424	ШШ албадан гүйцэтгүүлэх
2	НАЙРАМДАЛТХААН ХХК	5879043	730 259 492	182/ШШ2019/2032 182/Ш32024/00736	ШШ албадан гүйцэтгүүлэх
3	ОД ИННОВАШН ХХК	5629888	66 126 311	182/ШШ2023/01479 182/Ш32024/09140	ШШ албадан гүйцэтгүүлэх
4	ӨМГӨӨЛЛИЙН БАРИСТЕР КАСТОС ХХК	5959241	31 589 100	181/ШШ2022/00431 181/Ш32022/11628	ШШ албадан гүйцэтгүүлэх
5	УУШГИЙН АГУЙ ХХК	2569329	77 724 880	182/ШШ2024/00275 182/Ш32024/08426	ШШ албадан гүйцэтгүүлэх
6	Си эф си групп ХХК	5026911	26 290 320	183/ШШ2023/04310	ШШ албадан гүйцэтгүүлэх
7	Эм Эм Эм Би ХХК	5479347	35 487 689.37	102/ШШ2024/00647	ШШ албадан гүйцэтгүүлэх
8	Монгол Инфинити Шуудан ХХК	6330266	270 880 113	102/Ш32024/00719	ШШ албадан гүйцэтгүүлэх
9	Голомт-Инженеринг ХХК	5846781	107 467 598	102/ШШ2024/00722	ШШ албадан гүйцэтгүүлэх
10	МЕД КОДЕРС ХХК	6837158	25 028 204	182/ШШ2024/00274 182/Ш32024/08424	ШШ албадан гүйцэтгүүлэх
11	НАЙРАМДАЛТХААН ХХК	5879043	730 259 492	182/ШШ2019/2032 182/Ш32024/00736	ШШ албадан гүйцэтгүүлэх
Нийт			1 335 366 018		

Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй хуримтлагдсан авлагын **21,1 тэрбум** төгрөг буюу **48%** хувийг худалдаа үйлчилгээ, барилга, зам тээвэр, уул уурхайн салбарууд эзэлж байна. Зам, барилгын салбар нь улсаас тендер авч урьдчилсан гүйцэтгэлийн санхүүжилтийг тухайн ажил олгогч хариуцаж гүйцэтгэдэг ба барилга болон замын гүйцэтгэл бүрэн дууссаны дараа улсын төсвөөс санхүүжилтээ авдаг. Төслийн хугацаанд бараа материал, тээврийн үнэ огцом нэмэгдэж дээрх салбарууд алдагдал хүлээж, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаандаа төлж чадахгүй өр хуримтлагдаж байна. Газрын үйл ажиллагаанаас үл хамаарч нийгэм, эдийн засгийн хямрал нөлөөлж иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд шимтгэлээ төлөхгүй удаашралтай байна.

САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ТАЛААР

Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах албан бус хөдөлмөр эрхлэгчдийг шинээр хамруулах ажлын хүрээнд 2024 оны дөрөвдүгээр улирлын байдлаар нийт 9410 сайн дурын даатгуулагч хамрагдсан байна. Үүнээс сайн дурын даатгалд 8100 даатгуулагч, 0-3 хүртэлх насны хүүхэдтэй эх 780 даатгуулагч, сайн дурын даатгалын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг эх-135 даатгуулагч, малчин, туслах малчин 12 гэрээ байгуулан сайн дурын даатгалд хамруулсан ба тайлант хугацаанд нийгмийн даатгалын санд 12762.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 10209.6 сая төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 80 хувиар биелүүлсэн байна.

2024 оны 4 дүгээр улиралд сайн дураар даатгуулах тухай гэрээ байгуулсан боловч хуулийн хугацаандаа шимтгэлээ төлөөгүй 465 даатгуулагчид нийт 18,9 сая төгрөгийн алданги ногдуулж алдангийн нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн. Программд 2 бүртгэл үүссэн 53 даатгуулагч мэдээллийг залруулан ногдуулалт хийж ажилласан.

Сайн дурын даатгуулагчийн мэдээлэл аймаг, дүүрэгтэй давхардсан даатгуулагч эх-23, сайн дурын даатгуулагчтай давхардсан-9 даатгуулагч эхийн бүртгэлийг залруулсан. Давхар ногдуулалт хийсэн 28 даатгуулагч, Ажил олгогчийн цалин, сайн дурын даатгуулагч эх гэрээтэй давхардсан 39 даатгуулагчийн мэдээллийг засварлаж ногдуулсан. Сайн дурын даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 61 өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар:

Хувиар хөдөлмөр эрхлэгч иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сайн дурын даатгал, тэтгэвэр тэтгэмжийн даатгал, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ, бусад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, хамрагдалтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, ач холбогдлын талаар мэдээлэх, таниулах зорилгоор Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг зах худалдааны төвүүдтэй хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлэн “Нээлттэй хаалганы өдөрлөг” явуулын үйлчилгээг иргэд даатгуулагчдад хүргэн ажиллаж байна.

Чингэлтэй Дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран дүүргийн нийт иргэд даатгуулагчдад сайн дурын даатгал, тэтгэврийн даатгалын талаар зөвлөгөө мэдээллийг хүргэх, сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд видео танилцуулгыг бэлтгэн 1-24 дүгээр хороодын иргэний танхимаар дамжуулан хүргэж байна.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ / Шинэчлэл нийрүүл / 2024 он



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ / Шинэчлэл нийрүүл / 2024 он

Тус газраас иргэд, даатгуулагчдад Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомжийг сурталчлан таниулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх “Зөвлөө, Тусалъя” явуулын үйлчилгээг 2024 оны 06 дугаар сарын 5,6-ны өдрүүдэд Бөмбөгөр худалдааны төв, Хүчит шонхор худалдаан төв, Нарантуул- 2 төвүүдийн түрээслэгч нарт сайн дурын даатгал, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмж, тэтгэврийн даатгалын талаар зөвлөгөө




мэдээлэл өгч ажиллаа.

Нээлттэй хаалганы өдөрлөгт тэтгэврийн даатгал-173, сайн дурын даатгалын талаар 81, тэтгэмжийн даатгалын талаар 10, ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайлантай холбоотой 23 нийт 278 иргэд, даатгуулагчдад зөвлөгөө өгч ажилласан.





2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Нийгмийн даатгалын ажил үйлчилгээг иргэдэд сурталчлах, хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн ач холбогдлын талаар ойлголт өгөх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг дараах чиглэлийн хүрээнд 10:00-16:00 цагийн хооронд нийт 309 иргэнд хүрч, арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Үүнд:

- ✓ Ажил олгогч, даатгуулагч иргэдэд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, Нийгмийн даатгалын ажил үйлчилгээг таниулах, шимтгэл төлөлттэй холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө, мэдээлэл өгөх асуудлаар нийт 309 иргэн ;
- ✓ Иргэдэд нийгмийн даатгалд сайн дурын хэлбэрээр хамрагдахын ач холбогдлыг таниулах, сайн дурын даатгалд хэн хамрагдах боломжтой болох талаар дэлгэрэнгүй мэдээлэл зөвлөгөөг 58 иргэн ;
- ✓ Өдөрлөгийн үеэр иргэдийг сайн дураар сайн дурын даатгалд шинээр хамруулах, гэрээ байгуулах, гэрээ сунгах, шимтгэл төлөлт хийлгэх үйлчилгээнд 31 иргэн ;
- ✓ Тэтгэвэр, тэтгэмж тогтоох, шимтгэл төлж ажилласан хугацаа тооцох, хүсэлтийг цахимаар илгээж болох зэрэг иргэдийн авахыг хүссэн мэдээллээр асуусан асуултад бүрэн мэдээллийг 123 иргэн ;
- ✓ Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар мэдээлэл 42 иргэн ;
- ✓ Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах зарлал, мэдээллийг газрын албан ёсны фэйсбүүкээр олон удаагийн давтамжаар байршуулан мэдээллийг ажилтан албан хаагч нар 116 удаагийн давтамжаар шэйр хийж, мөн өдөрлөг зохион байгуулагдах газрын гадна дэлгэцээр 15 минут тутамд видео мэдээллийг түгээж, дотор талбайд цагаан хоолойгоор 1 цаг тутамд зарлал хүргэсэн.
- ✓ Өдөрлөгийн үеэр нийт 42 иргэний гар утсанд Нийгмийн даатгалын аппликейшний 2.0 хувилбарыг татаж, суулган өгч арга хэмжээг амжилттай зохион байгуулж,



Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид, МСҮТ, их дээд сургуулийн оюутнуудыг хамруулсан, нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах зорилготой "Даатгалтай ирээдүй" сэдэвт сургалтыг 3 дугаар сарын 26-29-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус аяны хүрээнд ерөнхий боловсролын 5 болон 50 дугаар сургуулийн 42 сурагч, 2 их дээд сургуулийн нийт 41 оюутан сурагч хамрагдлаа. Сургалтын явцад 9 оюутан, сурагчид гар утасны аппликэйшн суулгаж, нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар товч мэдээлэл хүргэсэн.



Ажил олгогчдын зөвлөгөөн зохион байгуулах: Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд, журам заавар, цахим үйлчилгээний талаар аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчдод сурталчлан таниулах, шимтгэл төлөлтийн тайланг үнэн зөв хугацаанд нь гаргах талаар мэдээлэл өгөх зорилгоор Ажил олгогч захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудын сургалт, зөвлөгөөнийг 2024 оны 11 сарын 20-ны өдөр танхимаар зохион байгууллаа.

Зөвлөгөөнд урилгаар "Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт, цаашид анхаарах асуудлууд сэдвээр НДЕГ-ын БХСГ-ын НД-ын бодлого хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн улсын байцаагч М.Бямбадулам оролцлоо.

ХНХСайдын 2023 оны А/199 дугаар тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан илгээх, хүлээн авах, хянах, баталгаажуулах журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цахимаар тайлан илгээх талаар зөвлөгөө мэдээлэл өгч, танилцуулсан.

Тус газар нь уг сургалт, зөвлөгөөний үеэр Нийгмийн даатгалын хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, даатгуулагчийнхаа нийгмийн баталгааг хангаж, улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулж байгаа 5 байгууллагыг "Шилдэг ажил олгогч"-оор шалгаруулж, өргөмжлөлөөр шагнаж урамшуулсан.

Албан хаагчдыг чадавхжуулах сургалтад хамруулах


Монголын бүтээмжийн төвтэй хамтран 2024 оны 3 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоонд дотоод аудит хийх, дотоод аудитор бэлтгэх сургалтад тус тасгаас тасгийн дарга М.Отгонцэцэг, байцаагч Б.Ануужин нар хамрагдаж сертификат гардан авсан.



Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор БНХАУ-ын Хөх хотод 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 04-дүгээр сарын 21-ний хооронд тус газрын ОШБ С.Доржпагам хамрагдлаа.





Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 2024 оны 05 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх захиргааны шийдлүүдийн талаар ОУХБ-ОУСС-ын сургалтад орлого шимтгэлийн тасгийн дарга М.Отгонцэцэг оролцлоо.





Газрын дотоод төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд

Газрын даргын баталсан 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр “2024 оны дотоод ажлын төлөвлөгөө”-нд тусгагдсан дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Номын сангийн булан тохижуулах, албан хаагчдын төрсөн өдрийн календарь гаргах: Хамт олны зэрэг хандлагыг эрхэмлэх, бие биедээ хүндэтгэлтэй хандах, нийтэч орчныг бүрдүүлэх, албан хаагчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэх зорилгоор номыг




тавиур болон төрсөн өдрийн тэмдэглэлт календарийн хийж байршууллаа.

Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах: Газрын албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулснаар албан хаагчдын эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Чингэлтэй Дүүргийн Эрүүл мэндийн төв-Эрүүл мэндийг дэмжих төвтэй хамтран албан хаагчдыг эрт илрүүлэгт бүрэн хамрууллаа.




Бусад ажлын хүрээнд

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/348 дугаар захирамжийн дагуу “ХОТОО УГААЯ” аянд нэгдэн орчны 50 метр газрыг угаан, иргэдийг эрүүл аюулгүй ая тухтай орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор тус газар нь 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр цэвэрлэгээг зохион байгуулан ажилласан.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэд даатгуулагчдад Нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор дараалал харгалзахгүй чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлж ажиллах хөгжлийн бэрхшээлтэй жолооч зогсох зогсоолыг газрын гадна талбайд хийж гүйцэтгэлээ. Нийслэлийн автозамын газар, Чингэлтэй дүүргийн замын цагдаагийн газартай хамтран газрын гадна талбайн замын тэмдэг, тэмдэглээг хийлгэх ажлын хүрээнд хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлсэн.



Тус газрын дэргэдэх Эцэг эхийн зөвлөлтэй хамтран 2024 оны 06 дугаар сарын 01-нд хүүхдийн баярын үйл ажиллагааг зохион байгууллаа.



ХАМРАЛТ, ОРЛОГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА М.ОТГОНЦЭЦЭГ

